



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

*БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн
бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн
Ч.Пунцагсүрэн*

Улаанбаатар хот
2018 он

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ

Сүүлийн 40 жилийн судалгаагаар, Монгол орны усны нийт нөөц жил тутам дунджаар **608,300.0 сая.м³ (564.8 км³/жил)** үүний 34,600.0 сая.м³ гол, мөрний, 500,000.0 сая.м³ нуурын, 62,900.0 сая.м³ (**19.4 км³/жил**) мөнх цас, мөсөн голын, 10,800 сая.м³ газрын доорх ус байна.

Төрөл	Нөөцийн хэмжээ (сая.м ³ /жил)	Эзлэх хувь
Нуур	500,000	82.2
Гол, мөрөн	34,600	5.7
Мөнх цас, мөсөн гол	62,900	10.3
Газрын доорх ус	10,800	1.8
НИЙТ	608,300	100.0



- Гадаргын болон газрын доорх усны нөөцийн 70 орчим хувь нь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг эзлэх талбайд бүрэлдэн бий болдог. Гадаргын усны нөөцийн ихэнх хэсэг нь хөрш орнуудад цутгана.
- Манай улс цэвэр усны нөөцөөр дэлхийн 145 орноос 22-т бүртгэгдэж, усны нөөц багатай орны тоонд багтдаг.




МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ

Жилд


- Хүн амын унд, ахуйд 74.9 сая.м³,
- Хөдөө аж ахуйд 264.7 сая.м³,
- Уул уурхайд 81.1 сая.м³,
- Үйлдвэр, барилгад 8.9 сая.м³,
- Цахилгаан станцуудад 44.7 сая.м³,
- Нийгэм, нийтийн үйлчилгээнд 20.0 сая.м³,
- Аялал жуулчлалд 1.4 сая.м³,
- Зам тээвэрт 3.6 сая.м³ буюу нийт

499.3 сая м³



УСНЫ НӨӨЦИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО

Байгалийн зүй
тогтолцоонд усны
үндэслэн усны
нөөцийг сав
газраар нь
хамгаалах, зохистой
ашиглах, нөхөн
сэргээх



- Усны нөөцийг дэлхийн жишгийн дагуу сав газраар нь хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого баримталж байна. Өөрөөр хэлбэл, усны нөөцийг ашиглах, хамгаалах асуудлыг засаг захиргааны нэгжээр бус, ус хуримтлагдах талбайгаар нь, усны байгальд оршин тогтнох, нөхөн сэргээгдэх байгалийн хуульд захируулан усны менежментийг хэрэгжүүлэхээр зорьж байна.

УСНЫ МЕНЕЖМЕНТТЭЙ ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

1. Усны тухай хууль,
2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
3. “Ус” үндэсний хөтөлбөр (УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоол),
4. “Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө (Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоол).



УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ

Усны тухай хууль:

4 дүгээр зүйл. Усны нөөцийн нэгдсэн менежмент

- Усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн.
- Усны сан бүхий газрыг төрийн байгууллагын зохицуулалттайгаар нийтээр ашиглана.
- Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг Усны нөөцийн зөвлөл батална.
- Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.
- Сав газар нь сав газрын захиргаатай байх бөгөөд сав газрын захиргааг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

УСНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ХЗДХЯ

- Эрх зүйн орчин

СЯ

- Хөрөнгө оруулалт, санхүүжилт

БОАЖЯ

- усны нэгдсэн бодлого
- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах

ГХЯ

Гадаад орон, олон улсын байгууллагатай хийх (хилийн усны болон бусад) гэрээ, хэлэлцээр байгуулах

БХБЯ

•хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ

УУХҮЯ

уул уурхай, хүнд үйлдвэрийн ус хангамж

ЭМЯ

ус, рашааны чанар, эрүүл ахуй

ЗТХЯ

усан замын тээвэр

БСШУСЯ


сургалт, судалгаа

ХХААХҮЯ

Бэлчээр, тариалангийн усжуулалт, хүнс, хөнгөн үйлдвэрийн ус хангамж

ЭХЯ

усны (сэргээгдэх) эрчим хүчийг хөгжүүлэх



Аймаг, нийслэл, сум дүүрэг, баг хорооны Засаг дарга
Хуулиар хүлээсэн эрх үүрэг

УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРОО

Усны тухай хууль:


9.1. Засгийн газар усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.5. Усны асуудлаарх салбар дундын зохицуулалт хийх, нэгдсэн удирдлагаар хангах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үүрэг бүхий **үндэсний хороо** ажиллуулах;

"Ус" үндэсний хөтөлбөр:

5.1. "Ус" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын гишүүн хариуцна.

5.2. "Ус" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалтыг хийх, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус **Усны үндэсний хороо** ажиллах ба түүнийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлнэ. Усны үндэсний хорооны дүрмийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРОО

Засгийн газрын 2017 оны 27 дугаар
тогтоолын 10 дугаар хавсралт

УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга - Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
- Гишүүд:
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
 - Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
 - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга (зөвшилцсөнөөр);
 - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга;
 - “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал.
- Нарийн бичгийн дарга - Орон тооны

УСНЫ ҮНДЭСНИЙ ХОРОО

- Усны үндэсний хорооны бүрэлдэхүүнийг “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017.01.25-ны өдрийн 27 дугаар тогтоолоор шинэчилсэн.
- Усны үндэсний хорооны орон тооны нарийн бичгийн даргын албан үүргийг БОАЖ-ын сайдын 2017.05.09-ний өдрийн А/116 дугаар тушаалаар БОАЖЯ-ны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга /Ш.Мягмар/-аар хавсран гүйцэтгүүлж байна.
- Усны үндэсний хорооны дүрмийг БОНХАЖ-ын сайдын 2015.12.04-ны өдрийн А/416 дугаар тушаалаар баталсан байгаа.



УСНЫ НӨӨЦИЙН ЗӨВЛӨЛ

- Усны нөөцийн зөвлөл нь Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гадаргын болон газрын доорх усны эрэл хайгуул, судалгааны ажлын тайланг хэлэлцэж, усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг батлах, усны нөөц ашиглахтай холбоотой техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), төсөл, хөтөлбөр, судалгааны ажил нь холбогдох хууль, дүрэм, аргачлалтай нийцэж буй эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх үндсэн чиг үүрэгтэй.
- Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг БОАЖ-ын сайдын 2017.08.18-ны өдрийн А/228 дугаар тушаалаар шинэчлэн батлаад байна.
- Зөвлөлийн дарга нь БОАЖЯ-ны ТНБД, дэд дарга нь БОАЖЯ-ны ГЗБУНБЗГ-ын дарга, нарийн бичгийн дарга нь ГЗБУНБЗГ-ын Усны нөөцийн хэлтсийн дарга, гишүүдэд БОАЖЯ-ны газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон эрдэмтэн, доктор нийлсэн 14 хүн байдаг.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ (2011.10.16)

- 4.1. Засгийн газар хот, суурины ус хангамж, ариутгах татуургын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 4.1.2. хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах үүрэгтэй **зохицуулах зөвлөлийн дүрмийг** батлах (*ЗГ-ын 2012.02.15, №46*),
- 9.1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байна.
- 9.3. Зохицуулах зөвлөлийн дарга, гишүүнийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Ерөнхий сайд томилно.

УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

- Сав газар нь сав газрын захиргаатай байх бөгөөд сав газрын захиргааг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.
- Усны тухай хуулийн 10.1: Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага усны харилцааны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 10.1.2. Монгол Улсын гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарилалт байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн сав газрыг байгуулж, сав газрын захиргааны бүтэц, зохион байгуулалтыг батлах;
 - 10.1.11. Сав газрын захиргааны даргыг томилох, чөлөөлөх;



УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Сав газрын захиргааны чиг үүрэг:

- Сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх орон нутгийн болон салбар дундын зохицуулалтыг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;
- бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;
- Усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
- Усны нөөцийн менежментийн төлөвлөгөөг үндэслэн хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлт гаргах, мэдээллийн санд оруулж бүртгэх;
- Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулах үндэслэлийг тодорхойлох;

УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГАА

Сав газрын захиргааны чиг үүрэг:

- Сав газрын хэмжээнд ус хангамжийн эх үүсвэрийн болон хаягдал ус зайлуулах цэг тогтоох;
- Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- Сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах;
- Сав газрын зөвлөл байгуулах тухай саналыг харьяалагдах орон нутгийн захиргаатай зөвшилцөн боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;
- Гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газрыг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэлийг боловсруулах;

УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

- “Сав газрын захиргаадын байршлыг тогтоох тухай” БОНХАЖС-ын 2015.02.26, №А-109, **СГ-ын 29 захиргаа →26,**
- “Сав газрын зарим захиргаадыг татан буулгаж, нэгтгэн зохион байгуулах, байршлыг тогтоох, бүтэц, орон тоо, дүрмийг батлах тухай” БОНХАЖС-ын 2016.03.24, №А/83, **СГ-ын 26 захиргаа →21)**

- Усны 21 сав газрын захиргаад (дунджаар 10 хүн)-д 206 хүн ажиллаж байна.
- Захиргаадын үйл ажиллагааны зардалд БОАЖЯ-наас улсын төсвөөс 2.1 тэрбум төгрөг зарцуулж байна.

Онон – Улз голын сав газрын захиргааны бүтэц, орон тоо

Ажлын байрны нэр	Орон тоо	Албан тушаалын зэрэглэл
Дарга	1	ТЗ-8
Усны менежмент төлөвлөлт, зохицуулалтын нэгж		
Усны нөөцийн нэгдсэн менежмент, төлөвлөлт, олон нийт сургалт хариуцсан мэргэжилтэн /бичиг хэрэг/	1	ТЗ-5
Үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Усны чанар экологи, төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Нуурын экосистемийн үнэлгээ, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Нягтлан бодогч (гэрээт)	-	ТҮ-7
Жолооч, нярав	1	ТҮ-3
Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах нэгж		
Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ-6
Газрын доорх усны нөөц, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Газар зүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Усны барилга байгууламж, ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-5
Нийт дүн	10	

УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ БҮТЭЦ, ОРОН ТОО

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын
2016 оны А-83 дугаар тушаалын 12 дугаар хавсралт



УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫГ БЭХЖҮҮЛЭХ



“САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН ХАМТЫН ОРОЛЦОО МЕНЕЖМЕНТ, АНХААРАХ АСУУДАЛ” СЭДЭВТ СЕМИНАР



УЛААНБААТАР ХОТ
2017 оны 02 сарын 14-15 өдөр

УСНЫ САВ ГАЗРЫН ЗАХИРГААДЫН БАЙРШИЛ, ОРОН ТОО

№	Сав газрын захиргааны нэр	Байршил	Орон тоо
1	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	Орхон аймаг, Баян-Өндөр сум /Эрдэнэт хот/	8
2	Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа	Хөвсгөл аймаг, Мөрөн сум	9
3	Дэлгэрмөрөн-Шишхэд голын сав газрын захиргаа	Хөвсгөл аймаг, Мөрөн сум	9
4	Идэр голын сав газрын захиргаа	Завхан аймаг, Идэр сум	7
5	Орхон-Чулуут голын сав газрын захиргаа	Архангай аймаг, Эрдэнэбулган сум	11
6	Хануй голын сав газрын захиргаа	Булган аймаг, Баян-Агт сум	6
7	Туул голын сав газрын захиргаа	Улаанбаатар хот	23
8	Хараа-Ерөө голын сав газрын захиргаа	Дархан-Уул аймаг, Дархан сум /Дархан хот/	10
9	Онон-Улз голын сав газрын захиргаа	Дорнод аймаг, Баяндун сум	10
10	Хэрлэн голын сав газрын захиргаа	Хэнтий аймаг, Хэрлэн сум /Чингис хот/	8
11	Буйр нуур- Мэнэнгийн талын сав газрын захиргаа	Дорнод аймаг, Хэрлэн сум /Чойбалсан хот/	10
12	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум /Чойр хот/	12
13	Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа	Дорноговь аймаг, Сайншанд сум /Сайншанд хот/	12
14	Онги-Таац голын сав газрын захиргаа	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум	9
15	Алтайн өвөр говийн сав газрын захиргаа	Өмнөговь аймаг, Даланзадгад сум	12
16	Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа	Баянхонгор аймаг, Баянхонгор сум	10
17	Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа	Завхан аймаг, Улиастай сум	9
18	Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа	Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум	6
19	Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа	Ховд аймаг, Үенч сум	9
20	Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа	Ховд аймаг, Жаргалант сум	9
21	Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргаа	Увс аймаг, Улаангом сум	7

УСНЫ САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ

Усны тухай хууль:

20.1. Сав газрын захиргааны **дэргэд** сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, **олон талын оролцоог хангах үүрэг бүхий орон тооны бус усны сав газрын зөвлөлийг** байгуулна.

20.2. Сав газрын зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны төлөөлөл, байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын алба, төрийн бус байгууллага, сум, дүүргийн иргэн, ус ашиглагч, эрдэмтэн, судлаач, усны мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна.

20.3. Сав газрын зөвлөлийг байгуулах, ажиллах нийтлэг журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.4. Сав газрын зөвлөл нь усны харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Хуульд 8-9 эрх, үүрэг тусгагдсан.

Зөвлөлийн статус, санхүүжилт тодорхой бусаас үйл ажиллагаагаа олигтой явуулж чадахгүй байна.

УСНЫ САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ

Сав газрын зөвлөлийг байгуулах, ажиллах нийтлэг журам (БОНХАЖС-ын 2013.04.22, №А-124):

- Сав газрын Зөвлөл нь сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөх, хяналт тавих, олон талын оролцоог хангах үүрэг бүхий байгууллага мөн.
- Зөвлөл нь усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилгод олон талт ашиг сонирхол бүхий оролцогчдын эрх тэгш, хариуцлагатай, хамтран ажиллах нөхцөлийг хангах зарчмыг баримтлан ажиллана.
- Нэг сав газарт нэгээс илүүгүй сав газрын зөвлөл байх бөгөөд зарим сав газрын байрлал, бүс нутгийн экосистемийн онцлог зэргээс шалтгаалж 2 ба түүнээс дээш сав газрыг хамарсан нэг зөвлөл байж болно.
- Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 31-45 хүртэл тооны гишүүдтэй байна.

УСНЫ САВ ГАЗРЫН ЗӨВЛӨЛ

Байгуулагдсан сав газрын зөвлөлүүд:

1. Онон голын сав газрын зөвлөл (БОАЖС-ын 2010.04.19, А/108)
2. Орхон голын сав газрын зөвлөл (БОНХС-ын 2011.12.21, А/465)
3. Увс нуур-Тэсийн голын сав газрын зөвлөл (БОНХС-ын 2013.12.10, А/354)
4. Улз голын сав газрын зөвлөл (БОНХС-ын 2014.03.11, А/78)
5. Туул голын сав газрын зөвлөл (БОНХС-ын 2014.07.17, А/262)
6. Хяргас нуур-Завхан голын сав газрын зөвлөл (БОНХС-ын 2014.10.08, А/351)
7. Алтай өвөр говийн сав газрын зөвлөл (БОНХАЖС-ын 2016.04.11, А/103)
8. Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын зөвлөл (БОНХАЖС-ын 2016.04.13, А/111)
9. Галба-Өөш-Долоодын говийн сав газрын зөвлөл (БОНХАЖС-ын 2016.04.26, А/123)
10. Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын зөвлөл (БОНХАЖС-ын 2016.04.26, А/123)
11. Сэлэнгэ голын сав газрын зөвлөл (БОАЖС-ын 2016.11.18, А/103)
12. Хар нуур-Ховд голын сав газрын зөвлөл (БОАЖС-ын 2016.11.18, А/104)
13. Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын зөвлөл (БОАЖС-ын 2017.05.12, А/123)
14. Орог нуур-Түйн голын сав газрын зөвлөл (БОАЖС-ын 2017.06.13, А/165)

“МОНГОЛ-УС” ТӨААТҮГ

Усны тухай хууль:

- 32.7. Хүн амын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуурга, усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бүхий толгойн барилга байгууламж төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын өмчлөлд байна.

“Ус” үндэсний хөтөлбөр:

- 3.5.7. Усны нөөцийн менежментийг гардан хийх, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцан ажиллах төрийн өмчийн корпораци, түүний салбаруудыг төв ба орон нутагт байгуулж ажиллуулах;

Монгол Улсын Засгийн газрын тогтоол (2011.11.23, 335)

- Усны нөөцийн менежмент хийх, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж, түүний дотор толгойн байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллах чиг үүрэг бүхий “Монгол Ус” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсугай.

“МОНГОЛ-УС” ТӨААТҮГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013.11.30

№390

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 11.5, 30.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн Газраас ТОГТООХ нь:

1. Усны тухай хуулиар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгогдсон дараах чиг үүргийг, гэрээний үндсэн дээр “Монгол Ус” Төрийн өмчит үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюунд зөвшөөрсүгэй. Үүнд:

- усны нөөцийг тооцоолох, усны тоо бүртгэл явуулах, усны хяналт-шинжилгээ хийх, усны сан бүхий газрыг нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших, ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам, зааврыг боловсруулах;
- усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих;
- голын гольдролыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;
- цооног өрөмдөх, худаг гаргах, усны барилга байгууламж барих, ашиглах, судалгаа хийх, дүгнэлт гаргах;

“МОНГОЛ-УС” ТӨААТҮГ

- улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ, сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах талаар дүгнэлт гаргах;
- хадлан, бэлчээр, тариаланг усжуулах инженерийн хийцтэй услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт хийж, байгаль орчны болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргах;
- хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоо метрээс их хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид хаягдал ус зайлуулах тухай дүгнэлт гаргах.

2. Улсын төсвийн хөрөнгөөр судалж, нөөц нь тогтоогдсон газрын доорх усны нөөцийн ордуудыг боломжит нөөцийн хэмжээнд ашиглуулах, ус хангагчийн үүргийг “Монгол Ус” төрийн өмчит үйлдвэрийн газраар гүйцэтгүүлсүгэй.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Усны үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ц.Бадрах нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд

Н.АЛТАНХУЯГ

С.ОЮУН

“МОНГОЛ-УС” ТӨААТҮГ

- “Монгол-Ус” ТӨҮГ нь Засгийн газрын 390 дүгээр тогтоолын дагуу Усны тухай хуулиар Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгогдсон зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай “Чиг үүргийг гүйцэтгүүлэх” гэрээг 2014 оноос эхлэн байгуулан ажиллаж, гэрээг 2016 оны 04 дүгээр сараас 3 жилээр сунгасан.
- Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усалгаатай тариалан, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргах;
 - Тус үйлдвэрийн газар нь 2014 онд 123, 2015 онд 146, 2016 онд 143 аж ахуйн нэгж ус ашиглуулах дүгнэлт гаргасан. Гаргасан дүгнэлтээр улс, орон нутгийн төсөвт жилд 30-40 тэрбум орчим төгрөг орж байгаа.

УСНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Усны тухай хууль:

21.1. Усны хайгуул, судалгаа явуулах, цооног өрөмдөх, усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнийг барих, тоноглох, ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усны шинжилгээ, аудит хийх ажлыг усны мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

21.2. Усны нөөцийн хайгуул, судалгааны ажлыг эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид олгоно.

21.3. Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

УСНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүрэг: (БОНХС-ын 2013.10.23, А-307)

Нэг. Усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл

1.1. Усны тухай хуулийн 21.1 дэх хэсэгт заасан чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулна:

1.1.1. Усны хайгуул, судалгаа явуулах;

1.1.2. Усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах;

1.1.3. Цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах;

1.1.4. Усны барилга, байгууламж барих, сэргээн засварлах, шинэчлэх;

1.1.5. Усны аудит хийх.

Засгийн газрын “Журам батлах тухай” /Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам/ 2006.06.14-ний өдрийн 137 дугаар тогтоол. *Мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах, хүчингүй болгох, эрх авахыг хүссэн өргөдөлд хавсаргах материал.*

Эрхийг журамд 3 жил, Усны тухай хуульд 5 жилийн хугацаатай олгохоор заасан.

УСНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

- 2006 оноос хойш **360** гаруй аж ахуйн нэгж, байгууллага усны мэргэжлийн байгууллагын эрх авсан ба үүнээс **100** гаруй аж ахуйн нэгж, байгууллагын эрхийн хугацаа дуусгавар болоод байна.
- Эрх нь хүчинтэй байгаа, эрхийн хугацаа нь дууссан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг цахим сайтад байршуулахаар ажиллаж байна.



“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

"Ус" үндэсний хөтөлбөрийн зорилго: Монгол орны усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан **улс орны хөгжлийн түлхүүр болгох**, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Стратегийн зорилт:

1. Монгол орны **усны нөөцийг хамгаалан** түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг хангах;
2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд **усны нөөц, чанарын хяналт-шинжилгээ**ний байнгын, тасралтгүй, шинэ дэвшилтэт технологид суурилсан сүлжээ байгуулан ажиллуулж мэдээлэл, удирдлагын шуурхай байдлыг хангах;
3. **Усны нөөцийн хуримтлалыг бий болгох**, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой хөгжлийг тэтгэх үндсэн нөхцөл бий болгох;

“УС” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

4. Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх **дэвшилтэт технологи нэвтрүүлэх**, үерийн аюулаас сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үүнд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, санал санаачилгыг хууль тогтоомжийн хүрээнд дэмжих;
5. Усны нөөц, ашиглалтын **менежментийг боловсронгуй болгож** ус ашиглалтын олон талт харилцааг зохицуулах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, боловсон хүчнийг чадавхижуулах;
6. Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах шинжлэх ухааны мэдээлэл, дэвшилтэт арга, технологийг уламжлалт зан үйл, ёс суртахууны хэм хэмжээгээр баяжуулан өсвөр, залуу үе, **нийт иргэдэд сурталчлан түгээн дэлгэрүүлж**, нийтийн үйл хэрэг болгох.

УСНЫ НӨӨЦИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө:

Засгийн газрын “Төлөвлөгөө батлах тухай” 2013.11.30-ны өдрийн 389 дүгээр тогтоолоор баталсан.

file:///C:/Users/User/Downloads/WRM_plan_of_Mongolia_MONGOL_web.pdf


Сав газруудын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө: Усны 18 сав газрын УННМТ-г БОАЖ-ын сайдын тушаалаар батлаад байна.

МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого



УННМ-ийн эрхэм зорилго: Хүн бүрийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилгоо биелүүлэх бүхий л хэрэгцээнд нь нийцсэн баталгаатай бөгөөд хямдхан, хүрэлцээтэй усаар хангахын зэрэгцээ ус хангамжаар улсын эдийн засгийн хөгжлийг тэтгэж, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгална. Монгол орны усны нөөц болон байгаль орчны эмзэг байдлыг сайтар ухааран, усны нөөц, байгаль орчны тулгамдсан асуудлыг Монгол хүн бүрийн болон улс орны эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж чадахуйц, бүтээмжтэй, үр ашигтай, хүн бүрт тэгш үйлчлэх чадавхтай, усны асуудлыг удирдан зохицуулах мэргэжлийн байгууллагын шинэ тогтолцоог бүх түвшинд цогц хэлбэрээр бий болгоно.

УННМ-ийн стратегийн зорилтууд



УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Усны тухай хууль:

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

11.1.2.усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усан орчинг нөхөн сэргээх, усны хөнөөлөөс урьдчилан сэргийлэх талаар сав газрын захиргаа, Засаг даргаас оруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийг хэлэлцэж, батлах;

Эрүүл ахуйн тухай хууль: (2016.02.04)

4 дүгээр зүйл. Хүрээлэн байгаа орчинд тавих эрүүл ахуйн шаардлага

4.1.Хүн амыг ундны болон ахуйн дараахь нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангана:

4.1.1.ундны болон ахуйн ус нь эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан, аюулгүй байх;

4.1.3.харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг энэ хуулийн 4.9-т заасан стандартыг хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хэрэгжүүлэх;

Бүх аймгийн төвийн усаар хангагч аж ахуйн нэгж, байгууллагууд ДЭМБ-ын аргачлалын дагуу “Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулан, дийлэнх аймаг, нийслэлийн ИТХ-аараа батлуулан хэрэгжүүлж байна.

УСНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

- “Газрын доорх усны хяналт-шинжилгээний хөтөлбөр”-ийг БОНХАЖС-ын 2016.07.07-ны өдрийн А/217,
- “Усны хяналт-шинжилгээ хийх журам”-ыг БОНХАЖС-ын 2016.07.07-ны өдрийн А/218 дугаар тушаалаар батлуулаад байна.
- Усны нөөцийг ашиглалт, чанарт байнгын хяналт тавихын тулд улсын хэмжээнд газрын доорх усны хяналт шинжилгээний 29 цэгт бүрэн автомат төхөөрөмж, 95 цэгт хагас автомат багаж төхөөрөмж суурилуулж, нийт 124 цэгийг усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээнд холбож, groundwater.mn сайтад оруулж, уг цахим хаягаар мэдээллийг өрөөнөөсөө хянах, нийтэд харуулах боломжийг бүрдүүлж байна.
- Цаашид хяналт-шинжилгээний цэгүүдийн тоог улам өргөжүүлэх (1000-д хүргэх) шаардлагатай байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

